



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 11


Улаанбаатар хот

Эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 18.7 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрмийн 3.3, 3.4 дахь заалтууд, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4.1.2, 4.5 дахь заалт, ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны журмын 6.1 дэх заалт, ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэл, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хурлын тэмдэглэл, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүрэлдэхүүнд Мэдээлэл, холбооны технологийн сургуулийг түшиглэн Дижитал технологийн судалгаа, хөгжлийн хүрээлэн байгуулсугай.

2. Дижитал технологийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн удирдлагыг томилох, бүтэц, чиг үүргийг хууль тогтоомжид нийцүүлэн батлахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Ректор (Т.Намнан)-т даалгасугай.



367010021



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот


ШУТИС ийн 2026 оны төсөв батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, ШУТИС-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.6, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.5 дахь заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2026 оны төсвийн орлогыг нэгдүгээр хавсралтаар, төсвийн зарлагыг хоёрдугаар хавсралтаар, хөрөнгө оруулалт, урсгал засвар, бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан төсвийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг Удирдах зөвлөлд тайлагнаж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Ректор (Т.Намнан)-т даалгасугай.

ДАРГА Д.ГАНТУЛГА



367010023



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот


Гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүнг үнэлэх тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5, 27.1.9 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралт "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.5 дахь заалт, ШУТИС-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.9.17 дахь заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.10, 4.5 дахь заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Ректорын 2025 оны үр дүнгийн гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг "бүрэн хангалттай" хэмээн үнэлсүгэй.

2.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Ректор, доктор (Ph.D), профессор Төмөрпүрэвийн Намантай 2026 оны үр дүнгийн гэрээг байгуулсугай.

ДАРГА Д.ГАНТУЛГА



367010025